



БАЯНЖАРГАЛАН СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ
Д.ДОРЖМАА ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgoovi@audit.gov.mn

2016-10 - 11 № 01/169.

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 203 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”-ын 1.9, аймгийн Аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Баянжаргалан сумын Эрүүл мэндийн төвийн 2016 оны 3 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн завсрлын аудитаар нийт 11,991,170.00 /арван нэгэн сая есөн зуун ерэн нэгэн мянга нэг зуун далан/ төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Аудитын хамрах хугацаанд нийт 3,972,860.00 төгрөгийн хүнсний материалыг орцын жишиг нормоор бодоогүй, хяналтгүй зарцуулж зардалд тайлагнасан байна.

Энэ нь Эрүүл мэндийн сайдын 2008 оны 267 тоот тушаалаар баталсан ... Хүний илчлэгийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ, Төсвийн тухай хуулийн 6.4.1-т /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах/ заасныг тус тус зөрчсөн байна.

2. Нийт 8,018,310.00 төгрөгийн шатахууны зарцуулалтыг жишиг нормоор бодож баримтжуулаагүй, зарцуулалтанд хяналт тавиагүй зардалд тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно/ заасныг зөрчсөн, Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар /автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормыг .../ баталсан жишиг нормыг мөрдөөгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.1-д /Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтлөөгүй/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:


- Холбогдох журам, жишиг орцын нормын дагуу хүнсний материалын зарцуулалтанд хяналт тавих, сар бүр тооцоо бодож баримтжуулж хэвших.
- Шатахуун зарцуулалтын тооцоог нормоор бодож баримтжуулах, зарцуулалтанд хяналт тавих
- Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Аудитын газарт 2016 оны 12 дугаар сарын 10-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Баянжаргалан сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч Д.Доржмаа, нягтлан бодогч Ц.Наранжаргал нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:

АХЛАХ АУДИТОР  Б.ГАНТУЯА

ЗӨВШӨӨРСӨН:

ЭРХЛЭГЧ  Д.ДОРЖМАА

НЯГТЛАН БОДОГЧ  Ц.НАРАНЖАРГАЛ

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангахаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлаага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцаач албан тушаалтанд хариуцлагаа тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.